

**НИЙГМИЙН АЖИЛТАН БЭЛТГЭХ БОЛОВСРОЛЫН  
ХӨТӨЛБӨРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД**  
(Өсвөр насныхны дундах дээрлэхэлт, хүчирхийллийн асуудлын жишээн дээр)

*С. Туяа*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль  
s.tuya@must.edu.mn*

*Г. Золжаргалан*

*Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль  
Нийгмийн эрүүл мэндийн сургууль  
zoljargalan@mnumts.edu.mn*

*Д. Жаргалсайхан*

*Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль  
Нийгмийн эрүүл мэндийн сургууль  
jargalsaikhan.t@mnumts.edu.mn*

**Хураангуй:** 2016 оноос эхлэн ННФ-ын дэмжлэгтэйгээр Нийгмийн ажилтан бэлтгэн гаргаж буй их, дээд сургуулийн баг, багш нарын хөгжлийг дэмжих, судалгаа шинжилгээний шинэлэг чиглэлийг хөгжүүлэх, нийгэмд бугшсан өсвөр насныхны дээрлэхэлт, түүний үр дагаварыг танин мэдэх анхдагч, хоёрдогч, гуравдагч урьдчилан сэргийлэлтийн арга зүйг бэлтгэгдэн гарч буй нийгмийн ажилтнуудад олгох, практик хэрэглээг бий болгох зорилгоор судалгаа, төслийн ажлыг төрийн өмчийн 4 их сургуульд хэрэгжүүлж байна. Энэхүү ажлыг бид сургалт, хичээлийн хөтөлбөрийн шинэчлэл, эрдэм шинжилгээ судалгаа, практик ажилтнуудад чиглүүлэн хэрэгжүүлж ирсэн бөгөөд явцын үнэлгээний судалгааг хийсэн. Үнэлгээний судалгааны хүрээнд чанарын болон тоон судалгааны аргыг ашиглаж, оюутнууд, төгсөгч, хөтөлбөрт хамрагдсан их, дээд сургуулийн багш, практик нийгмийн ажилтнуудыг хамруулан ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага тус тус хийсэн юм. Судалгааны үр дүнд Нийгмийн ажлын сургалтанд шинэлэг судалгааны нэг чиглэл бий болсон, сургалтын хөтөлбөрийн агуулгад тусгаж, оюутан залуучуудад мэдлэг ойлголт, ур чадвар олгох эхлэл бий болсон нь харагдлаа.

**Түлхүүр үгс:** Дээрлэхэлт, өсвөр нас, сургалтын хөтөлбөр, нийгмийн ажил

## I. УДИРТГАЛ ХЭСЭГ

Хүчирхийлэл, дээрэлхэлт бол хувь хүн, бүлэг хүний эсрэг амь насыг нь хохироох, хэвийн хөгжилд нь саад болох, бие махбод, сэтгэл санааны асар их үр дагавар бүхий нийгмийн асуудал юм. К.Мертон ба Robert A. Nisbet (1971), Schneder (1981), Eitzen & Zinn (2000) нарын судлаачид нийгмийн асуудлын талаарх ангилалыг хийсэн байх бөгөөд хүчирхийлэл, дээрэлхэлтийн үзэгдэл нь нийгмийн бүтэц, системийн тогтвортой байдлыг эвдэж задлах төдийгүй, гажсан зан байдлын улмаас үйлдэгддэг томоохон үр дагавартай үзэгдэлд [1] багтаасан байдаг.

Залуучуудын дундах хүчирхийлэл гэж хоорондоо ямар нэгэн хамааралгүй, танил болон танил бус 10-29 насныхны дунд, ихэвчлэн гэрээс гаднах орчинд тохиолдож байгаа аливаа хүчирхийллийг хэлдэг бөгөөд дээрэлхэлт, зодоон, дээрэм зэрэг хэлбэрүүдийг хамарч байна.

Жил бүр дэлхий дахинд 10-29 насны залуучуудын дунд 200,000 хүн амины гэмт хэрэг бүртгэгдэж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн 43%-ийг эзэлдэг. Залуучуудын дундах хүчирхийлэл гэмтэл, бэртэл, хүн амины хэргээс гадна сэтгэцийн эрүүл мэнд, архи болон мансууруулах бодисын хэрэглээ зэрэг олон асуудлыг үүсгэх эрсдэлт хүчин зүйл болдог [2]. Эдгээр нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, эрүүгийн эрх зүйн салбарын зардлыг үлэмж нэмэгдүүлж, бүтээмжийг бууруулах, хүчирхийлэл гарсан орон нутгийн үл хөдлөх хөрөнгийн үнэ цэн унахал хүргэн, нийгмийн харилцааг муутгах сөрөг нөлөөтэй[3].

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2017 онд гаргасан “Рецептив гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” судалгааны тайлан, зөвлөмжөөс харвал хорих ял эдэлж байгаа хүмүүсийн 50.4 хувь нь 2 ба түүнээс дээш удаа ял авсан, түүнчлэн хорих ялаас суллагдсан хүмүүсийн 47 орчим хувь нь дахин гэмт хэрэг үйлддэг [4] гэсэн үзүүлэлт байна. Эдгээр хүмүүсийн хувьд бага, өсвөр насандаа дээрэлхэлт, хүчирхийлэлд өртсөн, өөрсдөө үйлддэг байсан гэсэн олон улсын судалгааны үр дүнтэй давхцсан сэтгэл зүй-нийгмийн учир шалтгаантай байгаа нь манайд ч бас судлагдсаар байна. Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх ажил нь түүнийг ямар нэгэн гэмт хэрэг өдүүлэхээс өмнөх урьдчилан сэргийлэлтийн асуудлаас эхлэх ёстой. Сургуулийн өмнөх болон сургуулийн бага дунд ангид боловсрол олгох явцад нь хичээл сургалтаар дамжуулан эрх зүйн сургалт [5] зайлшгүй хэрэгтэй талаар салбарын судлаачид тэмдэглэж байгаа юм. Харин урьдчилан сэргийлэлтийн анхдагч, хоёрдогч түвшний үйлчилгээг хүргэх боловсон хүчин, хүний нөөцийн чадварлаг мэргэжилтэн бэлтгэх, өндөр ур чадвартай Нийгмийн ажилтнуудыг нийгэмд нийлүүлэх ажил их, дээд сургуулийн сургалтын байгууллагад чухал зорилт төдийгүй энэ нь өнөөгийн нийгмийн эрэлт хэрэгцээний нэг болоод байна. Манай оронд гэмт хэрэг, хүчирхийллийн шалтгаан болсон өсвөр насныхны дээрэлхэлтийн асуудлын тархалт, гүнзгийрэлт бага биш түвшинд байна. Энэ үзэгдэл нь өмнөх нийгмийн байгууллын үед ч (социалист чиг баримжаатай улс

орон байх үед) илэрсээр, янз бүрийн ноцтой үр дагавартай байсаар байсан ч мэргэжлийн түвшинд урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоогүй, мэргэжлийн бус байдлаар гэр бүл, сургууль, анги хамт олон, багш сурагч, сурагч-сурагчийн хоорондын харилцаагаар шийдвэрлэгдэж ирсэн хэмээн үзэж болохоор байгаа юм. Харин орчин үед залуучуудын хүчирхийлэл гэсэн үр дагаварт анхаарахаас илүүтэйгээр түүний учир шалтгаан болсон дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх ажлыг бид системтэйгээр, хүний нөөцийн чадварлаг багтайгаар хэрэгжүүлэхээс өөр аргагүй нөхцөл байдалд хүрээд байна.

Монгол улсад 13-15 настай хөвгүүдийн 63%, охидийн 19% нь сүүлийн 30 хоногт зодоонд оролцсон бол хөвгүүдийн 37%, охидын 20% нь сүүлийн 1 сард дээрэлхэлтэнд өртсөн байна (6). Залуучуудын дундах хүчирхийллийг судалсан кейс судалгааны тайлангуудаас харахад Улаанбаатар хотод нэгнийгээ дээрэлхэх, бүлэглэн зодолдох зэрэг асуудлууд ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсролын төвүүдэд байна. Түүнчлэн уг асуудал нь сурлагын амжилт, анги хамт олны уур амьсгал болон хүүхдүүдийн сэтгэцийн эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж, нийгэм сэтгэл зүйн хувьд гэмтэж байна [7].

Нийгмийн асуудал, түүний учир шалтгаан, үр дагаварыг судлан шинжлэх үүрэгтэй судлаач, нийгмийн ажилтнуудын хувьд Залуучуудын дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн загвар, анхдагч, хоёрдогч, гуравдагч урьдчилан сэргийлэх хөтөлбөр, стратеги, үйлчилгээг хэрэгжүүлэх нь зайлшгүй чухал байна.

Нөгөө талаас нэг стратегийн интервенцийн хэрэгжилтийн үр дүн бусад стратегийн хэрэгжилтээс хамаарч байдаг. Тухайлбал, нотолгоогоор дэмжигдсэн, хувь хүн болон гэр бүлд зориулсан урьдчилан сэргийлэх аргачлал нь эрх зүйн хүрээ, бодлого, эрх мэдлийн хүрээ болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажилтан, нөөц бололцоо бүхий бүтэц, байгууллагыг бэхжүүлэх зэрэг нийгмийн хүрээний асуудлыг сайжруулснаар хэрэгжүүлэхэд улам хялбар болдог байна[8].

Залуучуудын дундах хүчирхийлэл нь 2012 оноос хойш Монгол улсад судлагдаж байгаа нийгмийн томоохон асуудлын нэг юм. ННФ ТББ-ын дэмжлэг, санхүүжилтээр АШУҮИС, ШУТИС, МУБИС, ДХИС зэрэг төрийн өмчит их, дээд сургуулиудад 2015 оноос эхлэн өнөөг хүртэл залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх төслүүд хэрэгжиж байна. Эдгээр төслүүд нь их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх арга зүйг нэвтрүүлэх зорилгоор хэрэгжиж байгаа бөгөөд төслийн хүрээнд 3 төрлийн сурах бичиг, сургалтын хөтөлбөр мөн нэлээдгүй олон эрдэм шинжилгээний бүтээлүүд бий болжээ. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд залуучуудын дундах хүчирхийлэл тэр дундаа үе тэнгийнхний дээрэлхэлтийн асуудал гэж юу болох, Монгол улсад уг асуудлын нөхцөл байдал ямар түвшинд, ямар хэлбэрээр оршин байгааг тодорхойлоход чиглэж байв.

Цаашид залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх арга зүй, сайн туршлагыг бий болгохын тулд өмнө хэрэгжсэн төслүүдийн үр нөлөө, үр дүнг үнэлэх зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ. Судалгааг дараах багц асуултаар хязгаарлан гүйцэтгэв. Үүнд:

1.Залуучуудын дундах хүчирхийлэлтэй холбоотой ямар мэдлэг бий болсон байна вэ?

2. Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх ямар арга зүй, туршлага боловсруулагдсан байна вэ?

3.Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоо, хичээлийн хөтөлбөрт ямар нөлөө, үр дүнг бий болгосон байна вэ?

Энэ хүрээнд бид баримт бичгийн судалгаа, чанарын аргыг хослуулан ашигласан бөгөөд тухайн төсөл, үйл ажиллагаанд дэмжигдэн ажилласан их дээд сургуулийн нийгмийн ажлын багш, практик нийгмийн ажилтнууд, өсвөр насны дээрлэхэлтийг урьдчилан сэргийлэх таслан зогсоох хүрээнд шинэчилсэн хичээлийн хөтөлбөрүүдийг үзэж судлан төгссөн, нийгмийн ажлын салбарт ажиллаж буй төгсөгчдөөс судалгаа авч үр дүнгийн тайлбарлал хийлээ.

## **II. СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

Судалгааны 1, 2 дугаар асуултын хүрээнд баримтын судалгааны аргыг ашиглаж, судалгааны мэдээлэлд агуулгын шинжилгээ хийв. Уг судалгаанд ННФ ТББ-ын санхүүжилттэйгээр АШУҮИС, ШУТИС, МУБИС-д хэрэгжсэн төслүүдийн хүрээнд бий болсон дараах эх сурвалжуудыг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны 3 дугаар асуултын хүрээнд чанарын болон тоон судалгааны аргыг ашиглав.

Ингэхдээ оюутнууд, төгсөгчдөөс асуумж судалгаа авч, хөтөлбөрт хамрагдсан их, дээд сургуулийн багш нар, практик нийгмийн ажилтнуудтай ганцаарчилсан ярилцлага хийж, хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан арга зүйн дагуу хичээл судалсан оюутнуудтай фокус бүлгийн ярилцлага тус тус хийлээ.

Өсвөр насныхны дундах дээрлэхэлтийг таслан зогсоох, чадавхийг бий болгох төслийн үйл ажиллагаа нь мэргэжилтэн бэлтгэх тогтолцоонд ямар нөлөө, үр дүнг бий болгосныг тодорхойлох зорилготойгоор бид их, дээд сургуулийн 4 багш, 4 практик ажилтнуудтай ганцаарчилсан ярилцлага хийж, АШУҮИС болон ШУТИС-ийн n=21 төгсөгч, n=80 оюутнуудаас цахим асуумж авч, n=25 оюутантай фокус бүлгийн ярилцлага хийсэн. Цахим асуумж судалгаанд оролцсон оюутнуудын 32 нь мэдээллээ бүрэн оруулаагүй байсан тул хасч, нийт n=48 оюутны мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

Судалгаанд нийгмийн ажилтан бэлтгэж буй их дээд сургуулийн багш нар, тэр дундаа өсвөр үе, залуучуудын асуудлаар ННФ-ын төсөлд хамрагдсан ШУТИС,

АШУУИС, МУБИС-ийн нийгмийн ажил, эрүүл мэндийн нийгмийн ажлын хөтөлбөрийн багш нар хамрагдсан. Багш нарын хувьд нийгмийн ажлын мэргэжлийн хөтөлбөрт дараах ерөнхий эрдмийн суурь, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлийг 1-4 курсын оюутнуудад зааж байна. Үүнд:

- Залуучуудтай ажиллах нийгмийн ажил
- Нийгмийн эрүүл мэнд
- Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил
- Сэтгэл судлалын үндэс
- Ерөнхий социологи
- Нийгмийн ажлын орчин үеийн онол
- Нийгмийн ажлын технологи
- Хүүхэд хамгаалал
- Эмэгтэйчүүдтэй ажиллах нийгмийн ажил
- Нийгмийн ажлын удиртгал

Багш нартай хийсэн ярилцлага нь дараах агуулгын хүрээнд хийгдсэн.

Үүнд: тэнхим багш нартай холбоотой, зааж буй хичээлтэй холбоотой, хичээлийн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөний шинэчлэл, залуучуудын дундах хүчирхийллийг таслах зогсоох талаарх хичээлийн хөтөлбөртэй холбоотой сурах бичиг, гарын авлагын боловсруулалтад өгөх санал гэсэн чиглэлийн хүрээнд багтсан асуултуудыг Зураг 1-д нэгтгэн харуулав.

Зураг 1. Их дээд сургуулийн багш нарт чиглэсэн ганцаарчилсан ярилцлагын агуулга



Нийгмийн ажлын хөтөлбөрийн багш нарт бий болсон туршлага. Өсвөр насны хүүхдийн “дээрэлхэлт” гэсэн ойлголт, үзэгдлийн талаар их дээд сургуулийн нийгмийн ажлын хичээлийн агуулгад төдийлөн тусгаж байгаагүй шинэ байсныг ННФ-ийн төслийг хэрэгжүүлсэн их сургуулийн багш нар онцолж байна. Тухайлбал бидэнд дараах туршлага, үр дүн бий болжээ. Үүнд:

1. Хамаарал бүхий хичээлийн агуулгыг шинэчлэх, нийгмийн асуудал, үзэгдлийг талаар шинэ хандлага, байр суурийг бий болгосон хэмээн үзэж байна. Жишээ нь кейс судалгаа, орон нутгийн зураглал хийх аргачлалаар өсвөр насныхны дундах дээрэлхэлтийн харилцааг танин мэдэх, нөхцөл байдлыг тодорхойлох, орон нутагт түшиглэсэн үйл ажиллагаа явуулах, орон нутгийн төрийн байгууллага, ЕБС-тай хамтран арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах, гарын авлага боловсруулах, модуль боловсруулах зэргээр хамтран ажиллаж тодорхой чиглэлээр мэдлэгт хувь нэмэр оруулсан.

2. Тухайн хөтөлбөрийн багш болон багийн хөгжлийг дэмжсэн, салбарын практик үйл ажиллагааг өргөжүүлж, хороо, дүүрэг, яам тамгын газартай хамтын ажиллагааг үүсгэх, оюутан, багш нарын судалгааны ажлын хүрээг тэлсэн үйл ажиллагаа болсон байна.

3. Хөтөлбөрийн явцад тэнхим, хөтөлбөрийн багш нарын оролцоог хангахад анхаарч ажилласан ба энэ нь хичээлийн агуулгад хэрхэн тусгах, хичээлийн хөтөлбөрийн агуулгад хэрхэн тусгах зэрэгт ач холбогдолтой, багш нарын хамтын оролцоог дэмжсэн ажил байсан байна.

4. Түүнчлэн орон нутгийн нөөц бололцоо, боломжийг олж харснаар багш нарын хувьд өөрсдөө суралцах, судалгаа шинжилгээний шинэлэг сэдэв рүү орох, эрдэм судлалын ажилд хувь нэмэр оруулах сонирхолыг бий болгох боломжийг бүрдүүлсэн байна. Тухайлбал богино хугацаанд багш нар хамтран ажиллаж, бие биенээсээ хамтран суралцсан, төрийн байгууллага, бусад их дээд сургуулийн сүлжээ, түншлэлийг бий болгосон зэрэг туршлага хуримтлуулсан. Өөрөөр хэлбэл нийгмийн ажлын сургалтад багш, оюутны судалгааны ажил өргөжиж, тэлсэн ба бакалавр, магистрын түвшний судалгаа, илтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, багш нар докторын судалгааны ажлыг энэ сэдвийн хүрээнд өргөжүүлж тэлжээ.

*2016 онд жижиг хэмжээний судалгаа хийсэн илүү өргөжүүлэхэд тустай байсан. Хөтөлбөрийн 5-6 багш оролцсон, үр өгөөжтэй судалгааны ажил болсон. Асуудлыг өнгөц хардаг байсан бол ойлголт хандлагаа нэмэгдүүлсэн, оюутнуудад өгч байгаа мэдлэг, мэдээлэлд шинэлэг давалгаа орж ирсэн, сайжирсан гэж бодож байна. Жишээ нь хөтөлбөрөөс нэг улирдад 4-5 оюутан өсвөр насныхны дээрэлхэлтийн асуудлаар олон өнцгөөс харсан дипломын судалгаа хийж хамгаалсан. Энэ нь оюутанд сонирхолтой, нийгэмд байгаа асуудлыг өнгийж харсан ажил болсон гэж боддог.*

*Багштай хийсэн ярилцлагаас*

Өсвөр насныхны дундах дээрэлхэлттэй холбоотой судалгааны ажил хийгдсэн нь нийгмийн ажлын сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны хүрээнд дараах үр дүнгүүд гарчээ. Үүнд:

1. Өсвөр насныхны дундах дээрэлхэлттээс урьдчилан сэргийлэх сурах бичиг, гарын авлага, сургалтын модуль боловсруулагдсан. Тухайлбал, АШУҮИС-ийн НЭМ-ийн багш нарын боловсруулсан дээрэлхэлттээс урьдчилан сэргийлэх, анхдагч, хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн агуулгаар боловсруулагдсан гарын авлага, ШУТИС-ийн Нийгмийн ажлын хөтөлбөрийн багш нарын боловсруулсан орон нутагт дээрэлхэлттээс урьдчилан сэргийлэх, дасгал ажилтай гарын авлага, сургалтын модулийг өнөөдөр Залуучуудтай ажиллах нийгмийн ажил, Нийгмийн эрүүл мэнд, Сэтгэл судлалын үндэс гэх мэт хичээлийн хүрээнд оюутнууд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын эргэлтэд оруулсан байна.

2. ШУТИС-д нийт оюутнууд сонгон судалдаг “Сэтгэл судлалын хичээл”-ийн агуулгад багтаасан, МУБИС-ийн хувьд багш болох гэж буй нийт оюутнуудын сонгон судалж буй “Хүүхэд хамгаалал” хичээлийн агуулгад багтаасан байна. Оюутнуудын хувьд хожуу өсвөр насныхны бүлэгт багтах үеийнхэн учраас уг асуудлыг ойлгож хүлээн авах, урьдчилан сэргийлэх, арга зүйн талаарх мэдлэг мэдээлэлд ихээхэн анхаарч бүлгийн ажил, идэвх оролцоотой даалгавар ажилд сонирхолтой, бие даалтын ажлуудад санаачлагатай, гүйцэтгэл сайн байдаг талаар багш нар үнэлж байна.

3. Сургууль төгсөгч, албан үүрэгт шилжин ажиллаж буй мэргэжилтнүүдийн хувьд өсвөр насны хүүхдийн дээрэлхэлтийн нөхцөл байдлыг үнэлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг ажлын талбартаа хэрэгжүүлж байгаа сайн туршлага бий болж байна. Хүүхэд хамгааллын байгууллага, хороонд ажилладаг нийгмийн ажилтнууд, хүүхдийн тусламжийн 108-д ажиллаж байгаа төгсөгчдын хувьд хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэл зүйн асуудал, дээрэлхэлтийн талаар ойлголт өгөх, сургалт явуулах, ур чадвар олгох хэрэгцээ маш их байгааг дурдаж ном сурах бичгийн хэрэгцээ шаардлага их байгааг дурьдаж байна.

4. Өсвөр насныхны дээрэлхэлтийг таслан зогсоох чиглэлээр их, сургуулийн хамтран зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд хороо, дүүрэг ЕБС, холбогдох яам агентлагийн практик нийгмийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлж, нийгмийн асуудалд анхаарлыг чиглүүлэх, илтгэл хэлэлцүүлэх, хэвлэх үйл ажиллагаанд хэмжээнд хамтын ажиллагаа үүсгэх, улмаар оюутны дадлагын бааз түшиц газрын тоог нэмсэн үр дүн гарчээ.

Нийгмийн асуудлыг илүү өргөн хүрээнд харж, засаг дарга нар ч идэвхи санаачлагатай болсон байсан. ХУД-ийн 2 хорооны засаг даргын идэвхи, хандлага сайн байсан тул оюутнуудын дадлагыг удирдахад ч бас давуу талтай байсан. Дадлагын оюутнууд өөрсдөө санаачлагаараа залуучуудын асуудлыг хөндсөн нь дадлагын байгууллагад шинэлэг байсан. Дадлагын тайлангаа байгууллагадаа хамгаалсны дараа танхимд тайлан хамгаалалт хийдэг. Дадлага хийсэн оюутан маань үе тэнгийнхэн, хүүхдүүдийн дунд болдог асуудлыг харж дадлагын ажил хийсэн учраас дадлага удирдагчид танай оюутныг авахад нээлттэй гэх мэтээр дэмжиж байсан.

Багштай хийсэн ярилцлагаас

Тухайн хөтөлбөрийн багийн багшийн үндсэн ажлын ачаалал их, хичээл заах боловсруулах, оюутантай ажиллах зэрэг ажлын байранд зарцуулах норматив цаг их байдгаас зарим хүндрэл бэрхшээл гарч байсныг мөн дурьдсан. Тухайлбал:

*Тэнхим сургуулийн зүгээс:*

- Тухайн төсөл, хөтөлбөр үйл ажиллагаанд багш нарыг зориуд хамруулах нь идэвхи оролцоогүй хандах, багшийн үндсэн норматив ажлын ачааллаас хамаарсан бэрхшээл үүсэж байсан.
- Сургуулийн багш нар, удирдлагын хандлага янз бүр байсан. Зарим нь үл ойшоосон байхад зарим нь маш их дэмжсэн.

*Сургуулийн удирдлага, захиргааны зүгээс:*

- Зарим сургуулийн удирдлагаас багш нарыг мөнгө, төсөл хөөдөг гэж хардаг байдал ажиглагдсан. Сургуулийн удирдлагад төсөл үйл ажиллагааны зорилго, ач холбогдлыг сайн таниулах, багш нарын хандлага, судалгаа шинжилгээний арга зүйд өөрчлөлт ахиц өгдөг зэргийг ойлгуулах хэрэгтэй байсан.

*Хамтран ажиллаж буй практик байгууллага, яам, дүүрэг хороо, ЕБС-ийн зүгээс:*

- Ажилтан, мэргэжилтэн солигдох байгаа төрийн байгууллагад их байсан. Өсвөр насныхны талаарх ойлголт, дээрэлхэлт, урьдчилан сэргийлэх интервенци хөтөлбөрийн талаар ойлголт өгөх, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх талаарх яриа танилцуулга хийж, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх ажлын явцад ажлын байрны тогтворгүй байдал үйл ажиллагааны ахицад нөлөөлж байсан.
- Зарим салбарын удирдлагууд ихэвчлэн материаллаг зүйл хүлээх хандлага багагүй байгааг тэмдэглэж байсан. ЕБС-ийн захирал Нийгмийн ажилтны үйл ажиллагааг сайн ойлгодог бол дэмжлэг, оролцоо сайтай, нөгөө талаас ойлголт, дэмжлэг багатай захирлын хандлагыг нийгмийн ажилтантай хамтран өөрчлөх нь чухал болох нь харагдсан байна.

*Сургалтын хөтөлбөр дэх холбогдох хичээлийн агуулгын өөрчлөлт:* Нийгмийн ажилтан бэлтгэж буй их, дээд сургуулийн зарим хичээлийн агуулгад дараах өөрчлөлтийг хийжээ. Үүнд:

*Хүснэгт 1. Хичээлийн хөтөлбөрт тусгагдсан дээрэлхэлтийг таньж мэдэх, урьдчилан сэргийлэх арга зүйн агуулга, өөрчлөлт*

Хичээлийн нэр	Агуулга
Залуучуудтай ажиллах нийгмийн ажил	Залуучуудын дундах дээрэлхэлтийн асуудлыг танин мэдэх, нөлөөллийн болон урьдчилан сэргийлэх арга зүй, орон нутаг, гудамж, байранд тохиолдож буй дээрэлхэлтийн асуудал, ямар арга хэмжээ авах талаар хэлэлцүүлэг хийх, дотуур байрны нөхцөл ба оюутны асуудлын хүрээнд судалгаа хийх,
Үйлдвэрийн нийгмийн ажил	Ажилчдад туслах хөтөлбөр, ажилтны гэр бүлд чиглэсэн хөтөлбөр, тэдний өсвөр насны хүүхдэд зориулсан хөтөлбөрийн агуулга
Нийгмийн эрүүл мэнд	Өсвөр насны хүүхдийн нийгэм, сэтгэл зүйн онцлог, дээрэлхэлттэй холбоотой асуудал, өсвөр насныхны дарамт шахалт, урьдчилан сэргийлэх арга сурталчилах, захидал, дуу зохиох гэх мэт. Залуучуудын дундах хүчирхийлэл, урьдчилан сэргийлэлт, судалгаа баримт нотолгоо зэргийг авч үздэг.
Сэтгэл судлалын үндэс	Хөгжлийн сэтгэл зүйн онцлог, нялх балчир үеийн хүүхдийн сэтгэл зүйн, насны онцлогийг авч үздэг. Өсвөр насныхны сэтгэл зүйд юу нөлөөлдөг талаар ярихдаа дээрэлхэлтийн асуудлыг багтаадаг.
Хүүхэд хамгаалал	Залуучуудын нийгэм сэтгэл зүйн асуудал, дээрэлхэлт
ГБАНА	Үе тэнгийнхний дээрэлхэлтийг бууруулахад эцэг эхийн оролцоо
Нийгмийн бодлогын анализ	Олон улсад хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, Монгол улсын хүн амын талаар баримтлах бодлого, залуучуудын тухай хууль эрх зүйн орчин, залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээ, албан тушаалын тодорхойлолт, өсвөр залуучуудын нийгмийн асуудал, статистик шинжилгээ
Нийгмийн ажлын технологи	Хувь хүн, бүлэг, олон нийттэй ажиллахад шууд ашиглаж болох дасгал техник
Ерөнхий социологи	Жендер, нийгмийн давхраажилт, хотжилт гэх мэт асуудлаас үүдсэн нийгмийн асуудлыг кейс болгож ярьдаг.
Орчин үеийн онол	Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх онол, арга зүй, нотолгоонууд, үйлчилгээ, түүний сайн туршлага, монголд хэрэгжүүлж буй хөтөлбөрийн жишээ

Хичээл нь сургалтын хөтөлбөрт ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл эсэхээс хамааран өсвөр үеийнхний дээрэлхэлтийн асуудлаарх агуулга нь 2 цагийн лекц, 2 цагийн семинар хичээлийн агуулгаар зохион байгуулагдаж байна. Залуучуудын дундах хүчирхийлэл, дээрэлхэлтийн асуудлаар хичээл ороход оюутнууд маш сонирхон оролцдог байна. Хичээлийн хүрээнд олон улсын сайн туршлагыг судлах, нөлөөллийн ажил хийх, төсөл бичих, арга зүй, дасгал ажлаас бүрдсэн файл бүрдүүлэх, кейс хэлэлцүүлэг хийх, хичээлийн хүрээнд өсвөр үе, залуучуудын асуудлаар мэргэшсэн практик ажилтныг мөн эрсдэлт бүлгийн залуучууд, архины хамаарлын асуудлыг даван туулсан хүмүүсийн урьж ярилцлага уулзалт хийх зэрэг сургалтын арга зүйг голчлон хэрэглэж байна.

Оюутнууд олж авсан мэдлэгээ практикт ашиглаж буй байдал, онол практикийн уялдаа нийцтэй байдалд шинжилгээ хийхэд дараах үр дүнтэй байна. Тухайлбал, Практикт ажиллаж буй нийгмийн ажилтнууд мэргэжлийн байх тусмаа орон нутагт гарч буй нийгмийн асуудалд илүү хүчин чармайлт гаргаж байна. Илүү бүтээлч, сайн дурын ажил хийх, өөрөө төсөл хөтөлбөр санаачлан ажиллах нь илүү байна. Жишээ нь ХЗТЦ-ийн хүүхдүүдийн дунд байрнаасаа зугатах, зодолдох гэх мэт харилцааны бэрхшээлтэй байдлыг арилгах, урьдчилан сэргийлэх арга зүй мөн дүүргийн ГБХЗХГ-ын мэргэжилтнүүдийн хувьд залуучуудын дээрэлхэлт, хүчирхийллийг таслан зогсоох чиглэлээр ойлголт, арга зүй, ур чадвараа зайлшгүй чухал байгааг онцолж байлаа.

Мана улс залуучуудын орон, тэдэнд ээлтэй аюулгүй орчныг бий болгох, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, өсвөр залуучуудыг хөгжүүлэх, хувь хүн, бүлгийн хөгжлийг дэмжих бодлого үйлчилгээ чухал байгааг үндэслэл болгож, өсвөр насныхан, залуучуудтай ажиллах нийгмийн ажлын арга зүй, технологи, залуучуудын дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, аргачлалыг их дээд сургуулийн нийгмийн ажлын сургалтын хөтөлбөрт заавал судлах хичээлийн тоонд оруулах, сургалтын хөтөлбөрийн кредит цагт өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж багш нарын зүгээс санал нэгтэй дүгнэж байна.

Хэдийгээр нийгмийн ажлын сургалтын хөтөлбөрт үйлчилгээний арга аргачлал, технологийн агуулга хичээл бүрт заагддаг ч энэ нь орон нутагт ялангуяа залуучуудын бүлэгт үзүүлэх үйлчилгээ болж хүрэхдээ ашиглагдаж буй нь эргэлзээтэй байгаа юм. Орон нутагт байгаа нөөцөд тулгуурлан их дээд сургуулийн багш нарын зүгээс дараах байдлаар хамтран ажиллах боломж байна гэж үзсэн. Үүнд:

1. Сэтгэл зүйн боловсролыг нэмэгдүүлэх, зан үйл өөрчлөх гэх мэт хоосон орон зайд дээрэлхэлтийн талаарх бий болгосон мэдлэг мэдээллээ түгээх;
2. Залуучуудтай ажиллах албан хаагч, мэргэжилтний АТТ-д залуучуудтай ажиллах мэдлэг, ур чадварыг тусгайлан мэргэжлийн шаардлагад тусгахад холбогдох шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх;
3. Залуучуудтай ажилладаг мэргэжилтэн, нийгмийн ажилтнуудыг давтан мэргэшүүлэх сургалтын агуулгад өөрчлөлт хийх, өсвөр насны хүүхдийн дээрэлхэлтийн талаарх агуулгын нэмж оруулах, төрийн байгууллагатай хамтран сургалтын хөтөлбөр хамтран боловсруулах зэрэг боломж байна.

*Сайжруулах боломж, хэрэгцээ:* Нийгэм динамик хөдөлгөөнтэй байнга өөрчлөгдөн, нийгмийн ажлын салбарт шинэ шинэ онол, парадигм боловсруулагдаж байгаа энэ цаг үед Нийгмийн ажлын сургалтын хөтөлбөрийг цаг үетэй уялдуулан боловсронгуй болгох, шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай гэж үзжээ. Тэр дундаа олон улсын түвшинд залуучуудтай ажиллах нийгмийн ажлыг сайн туршлага, арга зүй,

аргачлалыг тусгайлан судлах, практик хэрэглээ болгох хэрэгцээ шаардлага байна.

Их дээд сургуулиудын Нийгмийн ажлын хөтөлбөр 1997 оноос сууриа тавьсан цаг үеэс хойш 7-9 удаа өөрчлөгдсөн оруулжээ. Хичээлийн нэршил, агуулга, кредит цагийг өөрчлөх хэрэгцээ дээд боловсролын шинэчлэлтэй холбоотойгоор хэрэгжсэн байна. Харин 2009 онд батлагдсан нийгмийн ажлын цөм хөтөлбөрийн стандартад хэвээр өнөөг хүртэл өөрчлөлт хийгдээгүй байгаа юм. Энэ стандарт батлагдсанаас хойш сургууль цэцэрлэг, хүүхэд хамгааллын тогтолцоо сайжирч, өсвөр үе залуучуудын асуудал, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, донтолтын гэх мэт нийгмийн асуудлуудад хариу үйлчилгээ, урьдчилан сэргийлэх хөтөлбөр үйлчилгээний хэрэгцээ өссөөр байна.

## Ү. ДҮГНЭЛТ

Энэхүү үнэлгээний судалгаагаар бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Нийгмийн ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй төрийн өмчийн их, дээд сургууль ялангуяа ННФ-ын дэмжлэгтэйгээр өсвөр насныхны дундах дээрэлхэлтийг танин мэдэх, бэлтгэгдэн гарч буй шинэ мэргэжилтнийг энэхүү нийгмийн асуудалд хариу үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхи бүхий хүний нөөцийг бэлтгэхэд мэргэжлийн багш нарын зүгээс тодорхой туршлага, чадавхи бий болжээ. Сурах бичиг, сургалтын гарын авлага боловсруулагдаж, эрдэм шинжилгээний судалгааны ажил бакалавр, магистрын түвшний төгсөлтийн ажлын судалгааны нэг төрөл чиглэл болсон байна.
2. Нийгмийн ажлын сургалтын хөтөлбөр тодорхой хичээлийн агуулгад тухайн сэдвийг багтааж, мэдлэг, ойлголтыг Нийгмийн ажлын төдийгүй бусад мэргэжлийн ангийн оюутнуудад сонгон суралцах боломжийг олгосон.
3. Пракик нийгмийн ажилтнуудын хувьд өсвөр насныхны дундах дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх арга зүйн мэдлэгт суралцах нь чухал байгаа бөгөөд академик сургалтын байгууллага, практик байгууллагууд хамтран салбар дундын түншлэлийг хөгжүүлэх, шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж байна.
4. Нийгмийн ажлын сургалтын хөтөлбөрийг цаг үетэй уялдуулан боловсронгуй болгох, шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Тэр дундаа олон улсын түвшинд залуучуудтай ажиллах нийгмийн ажлыг сайн туршлага, арга зүй, аргачлалыг тусгайлан судлах, практик хэрэглээ болгох хэрэгцээ шаардлага байна.

### НОМ ЗҮЙ

1. *박철현 (2010). 사회문제론: 이론, 실태, 지구적시각: 서울, pp.457*
2. *ННФ (2017). Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: Нотлох баримтын тойм.*
3. *УБ.Одонгэрэл. “Рецептив гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” судлаачийн зөвлөмж болон “Монгол Улсад ял эдэлж буй хүмүүсийн хүний эрхийн өнөөгийн байдал” судалгааны тайлан УБ., 2014*
4. *Г.Баттулга “Манай улс ханагүй шоронтой болох тогтолцоо руу шилжиж байна”*  
*[http://npost.mn/a/174180?fbclid=IwAR1Ex6gEfjAaaXLRXeGm4CX3BOeUubgQU\\_\\_3tvUuEO6M9ho4QzHlAyYJ7GaM](http://npost.mn/a/174180?fbclid=IwAR1Ex6gEfjAaaXLRXeGm4CX3BOeUubgQU__3tvUuEO6M9ho4QzHlAyYJ7GaM)*

5. *Т.Жаргалсайхан, Г.Золжаргалан, Б.Ариунсанаа. Залуучуудын дундах хүчирхийллээс сэргийлэх нь. Сурах бичиг. 2017. Хуу 10.*
6. *ДЭМБ. Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: Нотлох баримтын тойм. ННФ. Хуу IX.*
7. *ДЭМБ (2018). INSPIRE гарын авлага: Долоон стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа.*